



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/307

Хэрлэн сум

Үзэсгэлэнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын 09-ний “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулан Дэлгэрхаан суманд “БИДНИЙ МОНГОЛ БИЧИГ-2023” гар бичлэгийн үзэсгэлэн гаргах арга хэмжээний зардалд 1,090,000 (нэг сая ерэн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтийн түүх бидэнд чухал” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ